

Иргэдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах асуудлын тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Хүн худалдаалах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах, гадаадын иргэнд үрчлүүлж байгаа хүүхэд болон гадаадын иргэнтэй гэр бүл болж байгаа иргэдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын тухай” Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандийн илтгэл, мэдээлэлтэй ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд

1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, нөхөн төлбөр олгох, нэр хүндийг нь сэргээх, мөн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудлыг цогцоор нь хэлэлцэн шийдвэрлэх;
2. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн батлах.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт

1. Хүүхэд үрчлэлт, хүн худалдаалах гэмт хэрэг, гадаадын иргэнтэй гэр бүл болж байгаа асуудлаар нарийвчилсан судалгаа хийж, Гэр бүлийн тухай болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан Улсын Их Хуралд өргөн барих;
2. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар Тагнуулын байгууллагад хүн худалдаалах гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах эрх олгох буюу давхар харьяалалтай болгон зүйлчлэх;
3. Гадаадад зорчсон насанд хүрээгүй Монгол Улсын харьяат иргэнийг эх орондоо эргэж ирсэн эсэхийг хянах механизмыг бүрдүүлэх;
4. Гадаадад насанд хүрээгүй хүүхэд дагуулан зорчиж байгаа иргэдээс тухайн хүүхдийн талаархи бодит мэдээллийг шаардах, хянах эрхийг Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт олгох асуудлыг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх;

5. Засгийн газрын 2005 оны 234 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүн худалдах, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх;

6. Хил дамнасан хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар гадаадын улс орнуудтай хамтран ажиллах, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенци, хоёр болон олон талт гэрээний биелэлтэд хяналт тавих үүргийг Гадаад харилцааны яамны чиг үүрэгт оруулах;

7. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон нийт, ялангуяа хүүхэд, залуучууд, эмзэг бүлгийнхний дунд байнга зохион байгуулах;

8. Орон нутгийн хууль сахиулах байгууллагын дэргэд (цагдаа, тагнуул, прокурор гэх мэт) хүн худалдаалахтай тэмцэх тусгай нэгжийг байгуулж, ажиллуулах.